

“Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжүүлсэн ажлын тайлан

Нээлттэй засгийн түншлэлийг таниулан сурталчлах, долоо хоногийн арга хэмжээний талаарх мэдээллийг 2025.05.19-ний өдрөөс 2025.05.23-ны өдрүүдэд иргэн аж ахуй нэгжүүдэд сурталчлах ажлыг Стандарт хэмжил зүйн хэлтэс, Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгуулж ажиллалаа.

2025.05.20-ны өдөр Улиастай сумд үйл ажиллагаа явуулж буй хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид, аж ахуй нэгж хоршооны бизнес эрхлэгчидтэй “Олон нийтийн оролцоо “ сэдэвт уулзалт сургалт зохион байгуулж E-Mongolia.mn платформоор дамжуулан үйлчилгээ авахад анхаарах асуудал, хүндрэл асуудлын талаар санал солилцож мэдээлэл өглөө.



E-Mongolia.mn цахим платформд үйлчилгээ оруулсан аж ахуй нэгжүүд: Аймгийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын газар, Татварын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс зэрэг байгууллагууд үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл хийсэн.



9

2025.05.22-ны өдрийн НҮБХХ-тэй хамтран “Бизнес ба хүний эрх” сургалтад Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, ажлын алба, Аймгийн Орлогч дарга, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарыг хамруулсан.

Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног арга хэмжээний үер иргэд, аж ахуй нэгжүүдээс ирүүлж буй санал, сайжруулах арга хэмжээний тухайд:

- E-Mongolia.mn сайтад нэвтрэхэд заавал иргэн регистрийн дугаар, нууц үг хийхгүйгээр царай таних шинэ үйлдэл нэмбэл олон дахин код солих, код мартаж санах үйлдэл багасна.
- Малын А дансны лавлагаа энэ системд оруулбал тэтгэвэр тэтгэмж хөөцөлдөхөд хялбар болно. Заавал архив дээр оочирлож цаг зарцуулахгүй.
- E-Mongolia.mn системд үйлчилгээ оруулсан төрийн байгууллагууд мэдээ мэдээллээ иргэдэд ойлгомжтой байдлаар оруулж сурталчлан таниулах хэрэгтэй байна.
- Аж ахуй нэгжүүд тоон гарын үсгийг Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл зэрэгт ашиглаад дахин ашиглахгүй байна. Энэ тоон гарын үсгийг хэрхэн ашиглах тал дээр зөвлөгөө мэдээлэл хүслээ.